



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/198/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас:260512 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261885 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Аудитор: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 261885 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.ЖАВХЛАНБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 25 № 07/766

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 375,594.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Батлагдсан төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахад 60,222.0 мянган төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан;
- Нэмэлт санхүүжилтийн данснаас баримтын бүрдэл хангалтгүй 29,000.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Төсвийн жилд зарцуулаагүй 17,987.0 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, 93,006.2 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4

дүгээр зүйлийн 4.1.3, 15.1.3, 15.1.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аж үйлдвэрийн чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан хууль эрх зүйн бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийх, аж үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластрын зураглал гаргахад судалгаа хийх зэрэг эрдэм шинжилгээ судалгааны ажилд нийт 126,850.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 200,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 199,117.0 мянган төгрөгийг зарцуулж, 883.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 30 дугаар тогтоолоор “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт”-ийг баталж Төрийн нарийн бичгийн даргын 2024 А/16 дугаар тушаалаар 9 газар 99 орон тоотой байхаар тогтоосон байна.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголттой болсон бөгөөд дотоод аудитын үйл ажиллагааг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээс харахад яамны дотоод хяналтын тогтолцоо сул, зохих түвшинд хэрэгжихгүй байна. Иймд яамны удирдлагаас дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код         | Балансын үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>            | <b>3,718,069,764.31</b> | <b>4,070,104,282.40</b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b> | 25,599,691.84           | 17,987,901.84           |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>         | 25,599,691.84           | 17,987,901.84           |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                             | 25,599,691.84           | 17,987,901.84           |
| 31211       | Төрийн сангийн харилцах                   | 25,599,691.84           | 17,987,901.84           |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                             | 42,820.31               | 14,637,078.40           |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага           | 42,820.31               | 14,637,078.40           |
| <b>34</b>   | <b>УРЬДЧИЛГАА</b>                         | 116,308,000.00          | 237,198,250.00          |
| 34600       | Урьдчилж гарсан зардал                    | 116,308,000.00          | 220,798,250.00          |
| <b>3471</b> | <b>Урьдчилгаа тооцоо</b>                  | 00.00                   | 16,400,000.00           |
| 34714       | Томилолтын урьдчилгаа                     | 00.00                   | 16,400,000.00           |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                     | 3,576,119,252.16        | 3,800,281,052.16        |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>                 | 19,855,000.00           | 179,760,150.00          |
| 35110       | Тусгай зориулалттай материал              | 19,855,000.00           | 179,760,150.00          |
| 35200       | Дуусаагүй үйлдвэрлэл                      | 2,999,553,406.84        | 2,999,553,406.84        |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>                | 556,710,845.32          | 620,967,495.32          |
| 35410       | Бичиг хэргийн материал                    | 37,729,190.00           | 43,605,390.00           |
| 35420       | Аж ахуйн материал                         | 490,366,599.00          | 502,812,995.00          |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                           | 696,300.00              | 696,300.00              |
| 35440       | Түлш, шатах тослох материал               | 523,254.32              | 7,083,254.32            |
| 35470       | Бусад хангамжийн материал                 | 27,395,502.00           | 66,769,556.00           |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>        | <b>679,205,330.07</b>   | <b>536,925,536.84</b>   |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                     | 679,205,330.07          | 536,925,536.84          |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                       | 312,843,831.63          | 338,581,207.65          |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл                    | 44,700,000.00           | 44,700,000.00           |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл                     | (26,075,000.07)         | (40,975,000.11)         |
| 39205       | Машин тоног төхөөрөмж                     | 670,714,680.08          | 778,353,040.08          |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл                     | (488,911,552.59)        | (569,339,009.80)        |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил               | 416,458,533.27          | 459,358,533.27          |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл                     | (334,157,933.99)        | (356,058,540.79)        |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө                      | 114,583,445.37          | 114,583,445.37          |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл                     | (86,202,840.44)         | (93,775,760.37)         |
| 39217       | Номын фонд                                | 1,734,500.00            | 1,734,500.00            |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                   | 366,361,498.44          | 198,344,329.19          |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө                    | 1,488,065,523.57        | 1,575,115,523.57        |
| 39304       | Хуримтлагдсан элэгдэл                     | (1,121,704,025.13)      | (1,376,771,194.38)      |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>        | <b>4,397,275,094.38</b> | <b>4,607,029,819.24</b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>              | <b>2,770,410.00</b>     | <b>2,770,410.00</b>     |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>          | 2,770,410.00            | 2,770,410.00            |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                              | 2,770,410.00            | 2,770,410.00            |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                        | 2,770,410.00            | 2,770,410.00            |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг                  | 2,770,410.00            | 2,770,410.00            |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>           | <b>4,394,504,684.38</b> | <b>4,604,259,409.24</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>        | 4,394,504,684.38        | 4,604,259,409.24        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал           | 304,117,253.38          | 304,117,253.38          |
| 51101       | Өмч: - төрийн                             | 304,117,253.38          | 304,117,253.38          |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>               | 4,090,387,431.00        | 4,300,142,155.86        |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн                        | 1,163,954,403.75        | 4,090,387,431.00        |
| 51220       | Тайлант үеийн үр дүн                      | 2,926,433,027.25        | 209,754,724.86          |

|   |  |                  |                  |
|---|--|------------------|------------------|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ<br>ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,397,275,094.38 | 4,607,029,819.24 |
|---|--|------------------|------------------|

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт   | Өмнөх оны<br>гүйцэтгэл  | Тайлант оны<br>гүйцэтгэл |
|---------|--|-------------------------|--------------------------|
| 1       | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>8,861,522,617.82</b> | <b>7,162,990,500.00</b>  |
| 12      | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>115,689,908.82</b>   | -                        |
| 120     | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 115,689,908.82          | -                        |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 115,689,908.82          | -                        |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 22,829,291.84           | -                        |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 92,860,616.98           | -                        |
| 13      | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>8,745,832,709.00</b> | <b>7,162,990,500.00</b>  |
| 1310    | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 8,683,269,000.00        | 6,962,990,500.00         |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 8,683,269,000.00        | 6,962,990,500.00         |
| 1311    | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 62,563,709.00           | 200,000,000.00           |
| 131104  | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,563,709.00           | 200,000,000.00           |
| 2       | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>5,921,829,773.90</b> | <b>6,953,235,775.14</b>  |
| 21      | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>5,921,829,773.90</b> | <b>6,953,235,775.14</b>  |
| 210     | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 5,403,558,714.87        | 6,426,222,293.74         |
| 2101    | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 2,938,070,068.44        | 3,617,765,283.34         |
| 210101  | Үндсэн цалин   | 1,676,096,069.21        | 2,116,215,955.89         |
| 210102  | Нэмэгдэл   | 572,684,970.05          | 796,003,563.45           |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт  | 321,023,000.00          | 426,389,000.00           |
| 210104  | Урамшуулал   | 368,266,029.18          | 279,156,764.00           |
| 2102    | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 370,237,476.27          | 454,575,713.92           |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 253,810,038.75          | 311,714,605.31           |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 29,860,004.63           | 36,626,971.10            |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 23,480,494.28           | 18,700,564.65            |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 5,735,176.32            | 17,506,714.64            |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 57,351,762.29           | 70,026,858.22            |
| 2104    | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 129,601,980.58          | 98,802,081.09            |
| 210401  | Бичиг хэрэг  | 60,185,766.00           | 27,855,900.00            |
| 210402  | Тээвэр, шатахуун   | 12,619,973.55           | 13,060,000.00            |
| 210403  | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 33,341,549.03           | 35,836,185.09            |
| 210406  | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 23,454,692.00           | 22,049,996.00            |
| 2105    | <b>Нормативт зардал</b>  | 960,000.00              | -                        |
| 210502  | Хоол, хүнс   | 960,000.00              | -                        |
| 2106    | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 376,917,991.00          | 292,281,720.00           |
| 210601  | Багаж, техник, хэрэгсэл  | -                       | 5,396,280.00             |
| 210603  | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | -                       | 8,000,000.00             |
| 210604  | Урсгал засвар  | 376,917,991.00          | 278,885,440.00           |
| 2107    | <b>Томилолт, зочны зардал</b>  | 228,669,207.00          | 315,338,043.51           |
| 210702  | Дотоод албан томилолт  | 228,669,207.00          | 315,338,043.51           |

|             |  |                         |                       |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 747,297,012.28          | 959,664,328.65        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 738,549,658.28          | 906,137,474.65        |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 1,447,920.00            | 1,426,920.00          |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 158,934.00              | 158,934.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 7,140,500.00            | 51,941,000.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 611,804,979.30          | 687,795,123.23        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 146,251,098.80          | 260,691,970.00        |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 9,640,000.00            | 47,235,000.00         |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 455,913,880.50          | 379,868,153.23        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 518,271,059.03          | 527,013,481.40        |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 341,498,304.25          | 474,303,000.00        |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 22,892,600.00           | 116,388,000.00        |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, Урамшуулал                             | 200,950,000.00          | 252,200,000.00        |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 51,456,270.25           | -                     |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 66,199,434.00           | 105,715,000.00        |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | -                       | 51,827,481.40         |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                       | 51,827,481.40         |
| <b>2135</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>            | 176,772,754.78          | 883,000.00            |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 176,772,754.78          | 883,000.00            |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>2,939,692,843.92</b> | <b>209,754,724.86</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | 13,259,816.67           | -                     |
| 225005      | Үнэ төлбөргүй гарсан зардал  | 13,259,816.67           | -                     |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | (13,259,816.67)         | -                     |
| <b>5</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                       | <b>2,926,433,027.25</b> | <b>209,754,724.86</b> |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт                                      | Өмнөх оны гүйцэтгэл    | Тайлант оны гүйцэтгэл  |
|-------------|---|------------------------|------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b> | <b>8,771,432,400.8</b> | <b>7,162,990,500.0</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                    | <b>25,599,691.84</b>   | -                      |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>            | 25,599,691.84          | -                      |
| 120004      | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>       | 22,829,291.84          | -                      |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих     | 22,829,291.84          | -                      |
| 120009      | Бусад орлого                                  | 2,770,400.00           | -                      |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>          | <b>8,745,832,709.0</b> | <b>7,162,990,500.0</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                | 8,683,269,000.0        | 6,962,990,500.00       |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт             | 8,683,269,000.0        | 6,962,990,500.00       |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>            | 62,563,709.00          | 200,000,000.00         |

|             |  |                        |                        |
|-------------|--|------------------------|------------------------|
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,563,709.00          | 200,000,000.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>8,745,832,709.0</b> | <b>7,020,063,930.0</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>8,745,832,709.0</b> | <b>7,020,063,930.0</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>8,163,861,649.9</b> | <b>6,453,338,448.6</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 2,938,118,385.3        | 3,617,765,283.3        |
| 210101      | Үндсэн цалин   | 1,676,289,013.6        | 2,113,752,602.2        |
| 210102      | Нэмэгдэл   | 572,684,970.05         | 815,916,605.18         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 320,878,372.55         | 409,794,693.45         |
| 210104      | Үр дүнгийн урамшуулал  | 368,266,029.18         | 278,301,382.42         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 370,231,976.91         | 454,965,892.01         |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 253,804,539.39         | 308,663,192.01         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 29,860,004.63          | 36,575,800.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 23,480,494.28          | 18,287,800.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 5,735,176.32           | 18,287,900.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 57,351,762.29          | 73,151,200.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 81,155,706.78          | 121,447,587.09         |
| 210401      | Бичиг хэрэг  | 24,367,600.00          | 34,332,500.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 12,200,000.00          | 19,620,000.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 30,366,752.78          | 33,663,531.09          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 14,221,354.00          | 33,831,556.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 442,984,031.00         | 304,011,440.00         |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 53,458,700.00          | 12,767,100.00          |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 12,607,340.00          | 12,358,900.00          |
| 210604      | Урсгал засвар  | 376,917,991.00         | 278,885,440.00         |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 216,354,567.00         | 340,919,123.51         |
| 210702      | Дотоод албан томилолт  | 216,354,567.00         | 340,919,123.51         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 3,917,420,318.0        | 1,357,161,132.6        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 3,833,869,167.8        | 1,238,233,778.6        |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 1,447,920.00           | 1,426,920.00           |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 158,934.00             | 158,934.00             |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 81,944,296.25          | 117,341,500.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 197,596,664.80         | 257,067,990.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 185,687,204.80         | 209,832,990.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 11,909,460.00          | 47,235,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>581,971,059.03</b>  | <b>566,725,481.40</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 405,198,304.25         | 514,015,000.00         |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал   | 22,892,600.00          | 120,708,000.00         |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал   | 227,650,000.00         | 258,592,000.00         |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж  | 51,456,270.25          | -                      |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 103,199,434.00         | 134,715,000.00         |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | -                      | 51,827,481.40          |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                      | 51,827,481.40          |
| <b>2135</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | 176,772,754.78         | 883,000.00             |

|             |  |                      |                         |
|-------------|--|----------------------|-------------------------|
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 176,772,754.78       | 883,000.00              |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b>25,599,691.84</b> | <b>142,926,570.00</b>   |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | -                    | <b>150,538,360.00</b>   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | -                    | <b>150,538,360.00</b>   |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | -                    | 150,538,360.00          |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | -                    | 150,538,360.00          |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | -                    | <b>(150,538,360.00)</b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | 25,599,691.84        | (7,611,790.00)          |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | -                    | 25,599,691.84           |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | 25,599,691.84        | 17,987,901.84           |

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт                                   | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------|--|
